



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар	3
1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар	4
1.3. Сургалт, мэдээллийн талаар	4
1.4. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар	4
1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар.....	5
1.6. Хяналт шалгалтын талаар	5

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар.....	7
2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар	7

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:

7

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

8

4.1. Авто замын талаар	8
4.2. Авто тээврийн талаар	9
4.3. Төмөр замын талаар	10
4.4. Агаарын тээврийн талаар	11

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

11

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 09 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус яаманд 2018 оны 08 дугаар сард нийт 781 бичиг ирснээс хариутай 395 бичиг, хариугүй 388 бичиг, шийдвэрлэсэн 297, 13313,5 хуудас бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд орууллаа.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-170, Төрийн захиргааны удирдлагын газарт-179, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-181, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-69, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-65, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-39, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-78 шилжүүлсэн байна.

Ирсэн бичгийг байгууллагаар нь ангилж үзвэл: Монгол Улсын Засгийн газраас-7, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас-15, УИХ-ын гишүүн, байнгын хороодоос-26, яамдуудаас-92, Элчин сайдын яамдаас-4, Авилгатай тэмцэх газраас-7, Төрийн албаны зөвлөлөөс -4, аймаг, орон нутаг-59, дүүрэг, хорооноос-7, шүүх, цагдаагийн байгууллагаас-25, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдээс-51, харьяа байгууллагаас-170, компаниас-190, холбоодоос-12, бусад аж ахуйн нэгж, байгууллагаас-112 бичиг ирсэн байна.

Агуулгаар нь ангилбал: Санал авах-44, хүсэлт гаргах, хүргүүлэх, уламжлах-103, гүйцэтгэл, санхүүжилт хүссэн-51, тусгай зөвшөөрөл-8, шагнал-48, хариу ирүүлсэн-111, биелэлт, тайлан, мэдээ ирүүлсэн-55, мэдээлэл авах-31, асуудал шийдвэрлүүлж дэмжлэг хүссэн-21, бусад 309 бичиг тус тус байна.

Яамнаас гадагш-567 албан бичиг явуулж 2828 хуудас сканердаж able программд оруулсан.

Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар-131, Төрийн захиргааны удирдлагын газар-131, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар- 141, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-39, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-66, Хяналт -

шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-22, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-37 албан бичиг тус тус явуулсан байна.

1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн карталж удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд хувиарлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар яамны хэмжээнд иргэд, албан хаагчдаас нийт 44 өргөдөл, гомдол ирсэнийг удирдлагад танилцуулан цохолт хийлгүүлж холбогдох албан тушаалтанд хуваарилан ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 31, хяналтад байгаа 13, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй, шийдвэрлэлтийн хувь 70.45 хувьтай байна.

Дээрх өргөдөл, гомдол нь ээлжийн амралт олгуулах, цалинтай, цалингүй чөлөө хүссэн зэрэг агуулгатай байна.

Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцгийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтныг томилон тогтмол ажиллуулж байна.

1.3. Сургалт, мэдээллийн талаар:

Бүгд Найрамдах Хятад ард улсын Худалдааны яамнаас 2018 оны 8 дугаар сарын 10-31-ний өдрүүдэд зохион байгуулсан “Хөгжиж буй орнуудад зориулсан хил дамнасан цахим худалдааг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтанд Зам, тээврийн хөгжлийн яам болон харъяа байгууллагын 6 албан хаагчийг хамруулав.

1.4. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар:

Сайдын багцын харьяа төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог Сангийн сайдын батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн 08 дугаар сард нийт 212 ширхэг 9,1 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгаж төсвийн тухай хууль болон холбогдох журам дүрмийн дагуу төлбөр тооцоог хурдан шуурхай, үнэн зөв хийж гүйцэтгэн, хянан баталгаажуулж ажилласан.

Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн 07 сарын мэдээг харьяа байгууллагуудаас хүлээн авч төсвийн хэлбэлзэлтэй тулган шалгаж программд шивж нэгтгэн Сангийн яаманд 2018 оны 08-р сарын 08-ны өдөр хүргүүлсэн.

Засгийн газрын шилэн дансны хуудсанд байгууллагын 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд тайлагнасан.

Төсвийн тухай хуулийн 8, 29.4-т заасны дагуу саналаа ирүүлсэн Нийслэл, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Хэнтий, Ховд, Увс, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Завхан, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь зэрэг 21 аймаг, Иргэний нисэхийн ерөнхий газар, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Далайн захиргаа, МТЗ “ТӨХК”, Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудын ирүүлсэн төсвийн төслийн саналыг хянан боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын 2019 оны төсвийн төслийг

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/3822, 02/3939 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын 2019 онд худалдан авах, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг Сангийн яаманд 2018 оны 03/3856 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн материалыг сар бүр захиалгын хуудсын дагуу захиалан тарааж байна. 08-р сарын 30-ны байдлаар бичиг хэргийн зардал 17,203,905.0 төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 3,726,478.0 төгрөг, Шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 12,300,854.9 төгрөгийн зардлууд зарцуулагдаад байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 6 төсөл, арга хэмжээний 2.72 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу гүйцэтгэгчийн дансанд олгосон. Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу 3 төсөл, арга хэмжээний 115 сая төгрөгийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу чөлөөлж, гүйцэтгэгчийн дансанд олгосон.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст сар бүр тогтсон хугацаанд нийгмийн даатгалын тайланг гарган тушааж байна. Албан хаагчдын жирэмсний тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тооцоог гаргаж, нийгмийн даатгалын хэлтсээс нэхэмжлэн, дансанд орсон тухай бүр албан хаагчдад тооцож олгож байгаа болно. 08-р сарын 30-ний байдлаар нийт 17,153,271.0 төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тооцсоны дагуу 27 албан хаагчид олгосон.

1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулж байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээнээс 40-өөс доош хувийн биелэлттэй ажлын жагсаалтыг гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлыг холбогдох байгууллага, газруудтай хамтран хийж байна.

Яамны болон харъяа байгууллагуудын цахим хуудасны үйл ажиллагааг зохицуулах журмын төсөл боловсруулж, санал авахаар яамны цахим хуудаст байршуулав.

1.6. Хяналт шалгалтын талаар:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5^{2.1} дэх заалт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын баталсан 38-07-002,004/37 тоот удирдамжийн дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замд их хэмжээгээр орсон үерийн улмаас үүссэн эвдрэл, ашиглалтын байдал, тээврийн нөхцөл байдалд газар дээр нь үзлэг хийж Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлагын 2.8 дахь заалтыг тус тус зөрчиж байгаа тул Авто замын

хяналтын улсын байцаагчийн 38-07-004/73 дугаартай дүгнэлт, 38-07-004/42 дугаартай албан шаардлагыг “Гашуун сухайт авто зам” ХХК-д хүргүүлсэн.

Зам, тээврийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн удирдамжийн дагуу Улаанбаатар – Дархан –Сэлэнгэ чиглэлийн улсын чанартай авто замын ашиглалтын бэлэн байдалд 2018 оны 08 дугаар сарын 22-24-ны өдрүүдэд шалгалт хийсэн.

Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Улсын чанартай А0401 дугаартай Улаанбаатар-Дархан чиглэлийн хатуу хучилттай авто замын засвар арчлалт, ашиглалтын бэлэн байдал, нэмэлтээр хийгдсэн урсгал засварын ажил, зам тээврийн осол ихээр гардаг хар цэг болон А32 дугаартай Шаамар-Түшиг-Улсын хил чиглэлийн ургац тээврийн замын засвар, арчлалт ажил мөн улсын чанартай А0401 дугаартай хатуу хучилттай авто замаас салдаг Төв аймгийн Борнуур сумын 7.45 км хатуу хучилттай авто замын 30.65 у/м төмөрбетон гүүрийн байдалтай 2018 оны 08 дугаар сарын 25-ны өдөр ажилласан.

Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “Аж мянган”ХХК-ийн УБ-Сүхбаатар Дарьганга чиглэлийн автобус саатал гаргасан тул Автотээврийн тухай хуулийн 10.1-д заасан үүргээ биелүүлээгүй байх тул Зөрчлийн тухай хуулийн 14.6-ийн 10.1-д заасны дагуу 150000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.

Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн удирдамжийн дагуу “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ийн засварлуулсан 51 ширхэг ачааны хагас вагоныг төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах эсэхийг шалган дүгнэлт гаргах ажлын хэсэг 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр ажиллаж, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж байгаа талаар дүгнэлт гаргасан.

Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Ажлын хэсэг томилох тухай” 330 дугаар тушаалын дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн худалдан авсан 7 ширхэг ачааны хагас вагоныг 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдөр төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах эсэхийг шалган дүгнэлт гаргасан.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа Төмөр замын цагдаагийн хэлтсээс ирүүлсэн 1803000449 дугаартай эрүүгийн хэрэгт техникийн шинжээчийн дүгнэлт гаргаж, хүргүүлсэн.

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны 08 дугаар сарын 16-ны 38-07-20/ 38 дугаар Удирдамжийн дагуу Улаанбаатар өртөөний салбар замд “Сээкл” ХХК-ийн хүсэлт, Дорноговь аймгийн Далан жаргалан сумын нутагт “УБТЗ” ХНН-ийн 716км-рт “Баясал төгөс” ХХК-ийн хүсэлтийн дагуу тус тус төмөр замын шугамтай эрчим хүчний шугам ижил бус түвшинд огтлолцуулах техникийн нөхцлийг судалж шийдвэрлэв.

Зам, тээврийн хөгжлийн яамны Зам,тээврийн хяналтын хэлтсийн даргын баталсан 38-07-68/39 дугаар удирдамжийн дагуу “Шарын-гол” ХК-ийн Уурхайн салбар төмөр замд Их засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу хийсэн эсэхийг шалгаж хамтарсан ажлын хэсэг 2018 оны 8 дугаар сарын 31-ны өдөр 18-019 дугаартай дүгнэлт гаргасан.

Төмөр замын цагдаагийн газраас ирүүлсэн 7 гомдол мэдээллийн 2 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар, 5 гомдол мэдээлэлд 1803000147, 1803000155,

1803000156, 1803000168, 1803000171 дугаартай зөрчлийн хэрэг нээн шалгаж 6 хүнд 900,000 төгрөгний торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн байна.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар:

Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх нийт 16 журмын төслийг боловсруулах ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 191 дүгээр тушаалаар байгуулсан. Дээрх журмуудаас 1 журмын төсөл буюу “Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдалд үзлэг, шалгалт хийх, үр дүнг боловсруулах журам”-ыг батлуулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд нийт 15 журмын төсөл боловсруулах ажлын явц 8 дугаар сард дараах байдалтай байна. Үүнээс 6 журам батлагдаж, 4 журам батлагдах шатандаа, 2 журам төслийг боловсруулж дууссан бөгөөд “Захиргааны ерөнхий хууль”-ийн 62.1-т заасны дагуу яамны болон холбодох веб хуудаст байршуулан олон нийтээс санал авч байна. Үлдсэн 3 журмын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар:

Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яамыг шүүхэд төлөөлж нийт 11 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна. Үүнд:

- Иргэний анхан шатны шүүх-5
- Иргэний давж заалдах шатны шүүх-2
- Захиргааны анхан шатны шүүх-4

Шүүхээр хэлэлцэгдэж байгаа 11 хэрэг маргааныг ангилвал:

-Засгийн газрыг төлөөлж оролцож байгаа 3 хэрэг,
-ЗТХЯ-г төлөөлж 8 хэрэг байна.

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Улаанбаатар Дархан чиглэлийн авто замын авто замын зураг боловсруулах ажлын хөлс гаргуулахыг даалгах тухай” нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдөр болж нэхэмжлэлийн шаардлагыг хангахаар болсон байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 242 дугаар тогтоол батлуулсан.

Шивээхүрэн-Сэхэ боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 232 дугаар тогтоол батлуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажилд нэмж шаардагдах

хөрөнгийг тус төслийн 2 дугаар үе шатны төслийн хүрээнд шийдвэрлэх, мөн Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замын барилгын ажлыг Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх арга хэмжээг авах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон танилцуулгыг боловсруулж тогтоолын төсөлд санал авахаар холбогдох яамдад 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн албан бичгээр хүргүүлээд байна.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Авто замын талаар:

Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжид 2018 оны 6, 7 дугаар саруудад орсон аадар борооны үерийн улмаас үүссэн эвдрэлүүдийг засварлах ажлын тоо, хэмжээ тогтоож шаардагдах хөрөнгийн хэмжээг гарган Онцгой байдлын ерөнхий газраар дамжуулан Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 1, 8-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцүүлж 230, 238 дугаар тогтоолуудаар засварын ажилд шаардлагатай нийт 1.88 тэрбум төгрөг шийдвэрлүүлж засварын ажлыг хийж байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хэрэгжилттэй танилцах, хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий Азийн хөгжлийн банкны ажлын хэсэг 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс 8 дугаар сарын 06-ны өдрүүдэд Монгол Улсад ирж ажиллан зам барилгын ажилтай газар дээр нь танилцаж Харилцан ойлголцлын санамж бичгийг Азийн хөгжлийн банк, Сангийн яам болон Зам, тээврийн хөгжлийн яам хооронд 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан.

Монгол Улсын Гадаад харилцааны яам болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн ордон хоорондын байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн 4 дүгээр хуралдаанаар авто замын асуудлаар тодорхой санал бэлтгэн хэлэлцүүлж, Баянхошуу-Өвдөг боомтын гүүртэй зэрэгцүүлэн төмөрбетон гүүр барих, Таван толгой нүүрсний орд-Гашуунсухайт боомт чиглэлийн одоо байгаа хатуу хучилттай авто замтай зэрэгцүүлэн хүнд даацын авто зам барих асуудлаар хамтран ажиллах, Чойбалсан-Хавирга боомт чиглэлийн 125 км хатуу хучилттай авто зам барих асуудлыг түргэвчлэх, Цагаандэл-Уул-Өлзий авто замын хилийн боомтыг нээх үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар Хятадын талтай тохиролцон протоколд тусгасан.

Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сум чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах ажлын Зөвлөхийг сонгон шалгаруулж гэрээ байгуулагдсан.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Баян-Өлгий аймгийн төвийн 10.4 км авто замын шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Төв аймгийн Зуунмод сумын төвийн 2.6-р багт баригдах авто зам, гүүрийн барилгын ажил, Архангай аймгийн Ихтамир сумын 1.7км авто замын барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон.

Цахир-тосонцэнгэл чиглэлийн 127.1 км авто замын төсөвт магадлал хийлгэж, хамгаалалтын төмөр хашлагын хөрөнгийн эх үүсвэрийг 2019 оны төсөв тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн.

Дорнод аймгийн Галын голын 3бу/м төмөрбетон гүүр, Хөвсгөл аймгийн Ханх-Монд чиглэлийн 23км авто зам, Төв аймгийн Зуунмод сумын төвийн 0.78 км хатуу хучилттай авто замын ажлууд бүрэн дууссан бөгөөд чанар байдлын дүгнэлт гаргуулах ажлын хэсэг ажилласан.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажлын зургын даалгаврыг боловсруулж батлуулсан.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын Зөвлөхийг сонгох тендерийг зарласан.

Ажлын явц нь батлагдсан график төлөвлөгөөнөөс хоцрогдолтой буюу удаашралтай байгаа авто зам, гүүрийн барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг тодотгон шинэчлэн баталж, гүйцэтгэгч компани шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний дагуу барилгын ажлыг хийж гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

4.2. Автотээврийн талаар:

Автотээврийн салбарт төрөөс баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс саналыг авч, холбогдох саналуудыг тусган “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 31 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 1/4226 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд автотээврийн хэрэгслээс ялгарах утааг багасгах зорилгоор Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахуун, байгалийн хий /CNG/ оруулж ирэх, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулж ирэхийг үе шаттайгаар хориглох талаар Засгийн газрын тогтоолын төсөлд саналаа тусгаж Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/3860 тоот албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

“Журамд өөрчлөлт оруулах тухай” Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын шийдвэрийн төслийг боловсруулж, “Жолоочийн даатгалын сангийн дансанд хөрөнгө шилжүүлэх тухай” заалтад өөрчлөлт оруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдаар шийдвэр гаргуулан Сангийн яаманд хүргүүлэв.

Автотээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор цаашид хамтран ажиллах талаар Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 07/4138 тоот албан бичгийг “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-т хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлээр тус яаманд үүрэг болгосны дагуу автотээврийн хэрэгслээс ялгарах хорт бодисын хэмжээг бууруулах талаарх олон нийтийн санал асуулгыг 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Агаарын Бохирдлыг бууруулах газар, Нийслэлийн

тээврийн газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын вэб сайтад байршуулан олон нийтээс санал авч байна.

“Тээврийн аюулгүй байдал-Үндэсний тээврийн сүлжээг олон улсын тээврийн сүлжээнд нэгтгэх гарц” чиглэлээр чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр холбогдох санал, төслийн танилцуулгыг 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 02/4213 дугаар албан бичгээр Европын Холбооноос Монгол Улсад суугаа элчин сайдад хүргүүлсэн.

Нийслэлд зохион байгуулж буй авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 191 дүгээр тушаалаар Авто үйлчилгээний ангилал тогтоох үйл ажиллагааг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлсэн.

4.3.Төмөр замын талаар:

Монгол Улсын нүүрсийг ОХУ-ын Алс дорнодын боомт хүртэл тээвэрлэх туршилтын тээврийн бэлтгэл хангах төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар 2018 оны 08 дугаар сард батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Замын-Үүд дэх ложистикийн төвийн барилгын ажил дуусч удахгүй ашиглалтад орохтой холбогдуулан “Ашиглалтын өмнөх захиргаа байгуулах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 182 дугаар тушаал гарч дүрмийг батлуулсан.

Улаанбаатар хотноо 2018 оны 08 дугаар сарын 29-өөс 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газар хоорондын Байнгын зөвлөлдөх ажлын хэсгийн 4-р хуралдаан”-д санал боловсруулан оролцож хурадааны протоколд боомтын төмөр замын бүтээн байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой 6 төрлийн заалт тусгуулж батлуулсан.

БНХАУ-ын Хөх хотноо 2018 оны 08 дугаар сарын 27-оос 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн төмөр замын төлөөлөгчдийн комиссын зөвлөгөөнд оруулах саналыг нэгтгэж хуралд оролцох удирдамж, итгэмжлэлийг батлуулсан.

Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2018 оны 232 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор уг төслийн нарийвчилсан ажлын төлөвлөгөөг гаргаж, Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт боомтын бүсийн 10 га газарт хэрэгжих тээвэр логиистикийн төслийн асуудлаар Монгол-Тяньжины эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хамтарсан комиссын 8-р хуралдааны асуудлаар Тяньжин хотын Ардын засгийн газартай харилцаж, хамтран ажилласан.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 19 ААН, байгууллагын материалыг хянан шалгаж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 177, 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 190 дүгээр тушаалаар тус тус шийдвэрлэсэн.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 2 ААН, байгууллагын

материалыг Ажлын хэсгийн хурлаар хянан шалгаж 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдөр дүгнэлт гаргасан.

Усан замын тээврийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 155 дугаар тушаалаар 13 иргэн, аж ахуйн нэгжид олгосон.

4.4. Агаарын тээврийн талаар:

Монголын тал Япон консорциумтай хамтран 2018 оны 8 дугаар сарын 6,7-нд хувьцаа эзэмшигчийн гэрээний хэлэлцээг хийсэн бөгөөд тус хурлаар 32 асуудлыг хэлэлцээд байна.

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулахад Зам тээврийн хөгжлийн яамны төвшинд авах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан батлуулахаар ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний төсөлд Иргэний нисэхийн ерөнхий газар, Үндэсний хөгжлийн газраас санал авах шатанд байна.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар 2018 оны 8 сарын 27-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны боомтын холбогдох удирдлага нарыг хүлээн авч уулзан хилийн боомтын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Монгол, Беларусийн автотээврийн асуудлаарх Хамтарсан комиссын хуралдааныг Улаанбаатар хотноо 2018 оны 08 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уулзалтын дүнгээр Протокол үйлдэж гарын үсэг зурсан.

Монгол, Тайландын Засгийн газар хоорондын Хамтын ажиллагааны зөвлөлийн анхдугаар хуралдаан 2018 оны 09 дүгээр сарын 06-09-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдахтай холбогдуулан уг хуралдааны үеэр Монголын талын баримтлах удирдамж, ярианы сэдэвт зам, тээврийн салбарын чиглэлээр тусгах саналыг боловсруулж Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын дээд, өндөр төвшний айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнүүдэд зам, тээврийн салбарын асуудлаар тусгагдсан үйл ажиллагааны биелэлтийг гаргаж Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

Монгол Улс, Япон Улсын дээд, өндөр төвшний айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнүүдэд зам, тээврийн салбарын асуудлаар тусгагдсан үйл ажиллагааны биелэлтийг гаргаж Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаан 2018 оны 9 дүгээр сард зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан хуралдааны үеэр хэлэлцэх сэдэвт зам, тээврийн салбарын асуудлаар тусгах санал болон өмнөх хуралдааны холбогдох ажлуудын биелэлтийг гаргаж Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ